



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ГАНИБАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

додг. од. 26 № хт/340
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Солонго-1, 2” орон сууцны хороолол барих төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт !!! хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235028109



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Засгийн газрын XII байр, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976-11) 31 06 12, 7600 3333-1126
Факс: (976-11) 32 29 04

Цахим шуудан: info@mcud.gov.mn

Цахим хуудас: www.mcud.gov.mn


2024.02.22 № 02/555
танай 2024.02.05 -ны № ХЭГ/223 -г

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Таны 2024 оны ХЭГ/223 тоот албан бичгийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас "Солонго 1, 2" орон сууцны хороолол барих төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ДЭД САЙД



Э.ЗОЛБОО

172402553

**“СОЛОНГО 1, 2” ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ БАРИХ
ТӨСЛИЙН ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.ГАНИБАЛЫН АСУУЛГЫН ХАРИУ**

2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

Асуулга 1: Солонго-1, Солонго-2 хорооллын төслийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчээр шалгарсан гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 439 дүгээр тогтоолоор “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (EDCF)-гийн Худалдан авах ажиллагааны журам” болон батлагдсан тендерийн баримт бичиг, зураг, төсвийн дагуу шуурхай зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, тендерт шалгарсан ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ тухай бүр авч, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайдад тус тус даалгасан.

Үүний дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/191 тушаалаар төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийн нээлтийг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахад “Солонго 1” орон сууцны хороолол барих төсөлд “KOLON GLOBAL CORP.”, “ILSUNG CONSTRUCTION Co.Ltd”, “Солонго 2” орон сууцны хороолол барих төсөлд “KOLON GLOBAL CORP.”, “BOMI-KYERYONG JV”, “DSC-NH-ON Consortium” тус тус тендер ирүүлж, нээлтэд оролцогч компаниудын төлөөлөл, зөвлөх үйлчилгээний компанийн төлөөлөл болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны Монгол дахь төлөөлөгч нарыг байлцуулж танхимаар болон цахимаар зохион байгуулсан.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А-1/1104 тоот бичгээр төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хорооны техникийн саналын үнэлгээний тайланг тус яаманд ирүүлж, Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 3/1105 дугаартай албан бичгээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (EDCF)-гийн Худалдан авах ажиллагааны журам”-ын 1.06 хэсэгт заасны дагуу техникийн саналын үнэлгээний тайланг хянуулах, оролцогчдын санхүүгийн саналыг нээх зөвшөөрөл авах хүсэлтийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банканд хүргүүлж, тус банкны 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн MON-18, 19/23-1179 дугаартай албан бичгээр тендерийн санхүүгийн саналыг нээх зөвшөөрлийг авсан.

Үнэлгээний хорооноос 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр санхүүгийн саналыг оролцогч компаниудын төлөөллийг байлцуулан танхим болон цахимаар нээж, санхүүгийн тайланг ажилбар нэг бүрээр магадлан хянаж, нэгдсэн үнэлгээний тайланг боловсруулж, санал авахаар 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр, 2023 оны 06 дугаар

сарын 06-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банканд тус тус хүргүүлсэн бөгөөд тухайн банкнаас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн MON-18, 19/23-1800 дугаар албан бичгээр гэрээний хэлэлцээр эхлүүлэх зөвшөөрлийг баталгаажуулж өгсөн.

Түүний дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 1/2879, 1/2880 дугаартай албан бичгээр “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улсын “Колон Глобал корпорэйшн” ХХК-д захиалагчтай хэлэлцээр хийж гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн тус газраас 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А-1/2970 дугаартай албан бичгээр тендерт шалгаруулалтад шалгарсан “Колон Глобал корпорэйшн” ХХК-тай Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкны “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан (EDCF)-гийн Худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу хэлэлцээр хийж гэрээ байгуулах зөвлөмжийг Барилга, хот байгуулалтын яаманд ирүүлсэн.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны А/36 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээний хэлэлцээр хийх Ажлын хэсэг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 28-ны өдрийн хооронд гэрээний заалт бүрийг “Колон Глобал корпорэйшн” ХХК-тай хэлэлцэж 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 3/38, 3/39 дугаартай бичгээр гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг гүйцэтгэгчид хүргүүлснээр гэрээг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр байгуулаад байна.

Батлагдсан тендерийн баримт бичигт заасан гэрээний ерөнхий нөхцөлийн 4.4-т ерөнхий гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хариуцлагыг захиалагчийн өмнө бүрэн хариуцахаар заасан бөгөөд 4.4 (с)-д ерөнхий гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч бүрийг тэдгээрийн төлөвлөгөөт ажилбар эхлэхээс 28-аас доошгүй хоногийн өмнө захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч инженерт мэдэгдэхээр заасан. Одоогийн байдлаар ерөнхий гүйцэтгэгчээс төслийн туслан гүйцэтгэгчтэй холбоотой мэдээллийг эцэслэн тодорхойлж албан ёсоор захиалагч талд мэдэгдээгүй байна.

Асуулга 2: Тус төсөл нь ашиглалтад орсноор түрээслэх болон худалдах үнэ нь зорилт бүхий иргэдийн худалдан авах чадварт нийцэж чадах эсэх талаар

Төслийн хүрээнд бий болох орон сууцны барилга, байгууламжийг ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажил эхэлсэн өдрөөс 41 сарын хугацаанд буюу 2027 онд багтаан ашиглалтад оруулах бөгөөд орон сууцны түрээслэх болон худалдах үнийг барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импортын банкттай 2020 онд байгуулсан зээлийн хэлэлцээрт заасан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн өртөг, зорилтот бүлгийн иргэдийн тухайн үеийн өрхийн дундаж орлого, худалдан авах чадвар, төрөөс олгох татаасны хэмжээ зэргийг харгалзан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас тогтоох хуулийн зохицуулалттай байна.

Төслийн хүрээнд баригдах нийт 285.0 мянган м.кв талбай бүхий 5002 айлын орон сууцыг иргэдийн өрхийн орлогын түвшин, худалдан авах чадварт нь нийцүүлэн энгийн болон түрээслээд өмчлөх зориулалтаар зорилтот бүлгийн иргэдэд урт хугацаанд түрээслүүлэх чиглэлийг барьж байгаа бөгөөд төслийн орон сууцны нэгж м.кв талбайн өртөг нь 796.5 мянган ам.доллар буюу 2.7 сая төгрөг болох урьдчилсан тооцоо 2024 оны байдлаар гарсан.

Төслийн хөнгөлөлттэй зээлийн хугацаа 40 жил, жилийн хүүгийн хэмжээ 0.15 хувь бөгөөд эхний 10 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлсөн зэргийг харгалзан үзэхэд нэг өрхийн сарын түрээсийн дундаж төлбөр 499.8 мянган төгрөг байх тооцоо хийгдсэн. Үүнийг өрхийн өр орлогын жишиг харьцаа болох 45 хувьтай уялдуулан авч үзэхэд 1,110.0 мянган төгрөгийн орлоготой өрх төлөх боломжтой үнэ бөгөөд Улаанбаатар хотын нэг өрхийн дундаж мөнгөн орлого 2,063,887 төгрөг /Үндэсний статистикийн хорооны 2022 оны мэдээ/ байна.

Хүн амын орон сууцны тооллогын 2022 оны дүнгээс харахад манай улсын 941,547 өрхийн 32.1 хувь нь буюу 302,237 өрх нь инженерийн дэд бүтцийн шаардлага хангасан орон сууцанд амьдардаг бол 29.7 хувь буюу 279,639 өрх нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин хороололд, 38.2 хувь буюу 359,671 нь гэр сууцанд тус тус амьдарч байна.

Харин Нийслэл Улаанбаатар хотын 50.1 хувь буюу 216,989 өрх нь гэр хорооллын бүсэд инженерийн дэд бүтцийн хангамжгүй байшин болон гэр сууцанд амьдарч байна. Энэ нөхцөл байдал нь Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлын 75 орчим хувийн бүрдүүлээд байна. Иймд Улаанбаатар хотын иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдруулж, үр бүтээмжтэй ажиллаж, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэхэд нэн тэргүүний авч хэрэгжүүлэх арга хэмжээг эдгээр иргэдийн орон сууцжуулах, өрхийн орлого, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, хөдөө, орон нутагт шилжүүлэхэд хандуулах шаардлагатай байна.

Асуулга 3: Төслийн барилга угсралтын ажилтай холбоотой төрөөс олгох зөвшөөрлүүд болон тулгамдаж байгаа асуудлуудын талаар

Төсөл хэрэгжүүлэх нэгж /"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК/-ээс төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авахаар 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/1195 дугаар бичгийг төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд бүрдүүлсэн Аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн 2023 оны 000222145 дугаар гэрчилгээ, Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх 2023 оны №01122-2023/03814 дугаар гэрээ, Архитектур төлөвлөлтийн 2018 оны МКР2018/29-37 дугаартай даалгавар, "Солонго 1, 2" орлогод нийцсэн орон сууцны хотхоны 2022 оны батлагдсан загвар зураг, "Солонго 1" орлогод нийцсэн орон сууцны хотхоны эхний ээлжийн 17 блок барилгын 2022 оны батлагдсан ажлын зураг, "Солонго 1" орлогод нийцсэн орон сууцны хотхоны зориулалтын барилгын талбайн 2021 оны инженер-геологийн судалгааны тайлан, Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийн актыг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авсан 2023 оны АА2023/0362 дугаартай акт, "Солонго-1 орон сууцны цогцолбор хороолол" төслийн байгаль орчны төлөв байдлын 2023 оны суурь судалгааны тайлан, Эрчим хүчний яамны 2021 оны №43/2021/252 дугаар техникийн нөхцөл, Барилга, байгууламжийн зураг төслийн 2022 оны 1172/2022 дугаартай магадлалын дүгнэлт, Цахилгаан эрчим хүчээр хангах 2023 оны 15/01671/23 дугаартай

техникийн нөхцөл, Барилга, хот байгуулалтын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Колон Глобал корпорэйшн” ХХК хооронд байгуулсан 2023 оны №2023/273 дугаартай гэрээ болон бусад холбогдох материалуудын хамт Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан Барилгын салбарт ажиллах гадаадын иргэн, хуулийн этгээдийн ажиллах зөвшөөрөл болон бусад холбогдох тусгай зөвшөөрлийг ерөнхий гүйцэтгэгчээс гаргуулж авахаар хүлээгдэж байна.

Мөн ерөнхий гүйцэтгэгч төслийн талбайд хамгаалалтын түр хашааг барих ажлыг эхлүүлэн гүйцэтгэж байх явцад “Солонго-1” төслийн барилгын талбайн баруун талд залгаа хашаанд байрлах Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн зүгээс тэдний цэргийн ангийн орц, гарцыг хаасан гэх асуудлыг үүсгэж төслийн талбайн бэлтгэл ажлыг түр зогсоосныг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газартай 2020 онд байгуулсан зээлийн хэлэлцээрт Монгол Улсын талаас төслийн гадна инженерийн шугам сүлжээ, авто замын асуудлыг шийдвэрлэхээр заасан бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 15.0 тэрбум төгрөгийг батлагдсаны дагуу эхний ээлжийн 17 блок барилгыг хүлээж авахад шаардлагатай гадна инженерийн шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулж байна.

Монгол Улсын талаас төслийн гүйцэтгэлд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгэхэд 14.9 тэрбум төгрөг шаардагдах бол төслийг хүлээн авахад шаардагдах гадна цахилгаан хангамж, холбооны шугамын угсралтын ажилд 19.5 тэрбум төгрөг, гадна дулаан, цэвэр ус, ариутгах татуургын шугамын угсралтын ажилд 4.6 тэрбум төгрөг, нийт 39.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Монголын талаас хариуцах тооцоо гарч, зураг төсвийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 2374/2022 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажуулаад байна.

Иймд Монгол Улсын төсвийн тухай хуульд дээрх хөрөнгийн үлдэгдэл 24.0 тэрбум төгрөгийг 2025-2027 оны хооронд шат дараатайгаар тусган батлуулах шаардлагатай байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

2024. 02. 16 № 01 / 840
танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай


Таны 2024 оны “Асуултын хариу бэлтгүүлэх тухай” ХЭГ/223 дугаар албан бичгээр ирүүлсэн “Солонго-1, 2” орон сууцны хороолол барих төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын асуулттай танилцлаа.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Солонго” орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төслийг БНСУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ба уг төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа байгууллага хариуцаж байгаа тул төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох байгууллагад нь хандаж гаргуулах нь зүйтэй байна.

“Солонго-1, 2” орон сууцны хороолол барих төсөлтэй холбоотойгоор нийслэлийн хэрэгжүүлж байгаа ажлын товч мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАРЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200418

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Солонго-1, 2” орон сууцны хороолол барих төслийн хэрэгжилтийн талаарх товч танилцуулга мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар гаргалаа. Үүнд:


1.Инженерийн бэлтгэл арга хэмжээний талаар:

Солонго-1 орон сууцны хорооллын 510 метр үерийн хамгаалалтын суваг болон 1000 метр борооны ус зайлуулах шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Солонго-2 орон сууцны хорооллын 1000 метр барилгын дээврийн борооны ус зайлуулах шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.

2.Дулаан хангамжийн талаар:

“Солонго-1, 2” нийт төслийн хэмжээнд 29.7 Гкал/цаг дулаан шаардагдах Эрчим хүчний яамнаас 2021.10.01-ны өдрийн №073/2021 дугаартай “Солонго-1” хороололд 6 Гкал/цаг, 2021.06.03-ны өдрийн №038/2021 дугаартай “Солонго-1” хороололд 3 Гкал/цаг, 2021.04.29-ны өдрийн №027/2021 дугаартай “Солонго-2” хороололд 4 Гкал/цаг, нийт 13 Гкал/цаг дулаанаар хангах техникийн нөхцөл олгосон. Өргөх насос станц №7-г өргөтгөж, эх үүсвэр шийдвэрлэгдсэний дараагаар үлдэгдэл 19.7 Гкал/цаг дулааныг хангах боломжтой болох бөгөөд дараах ажлыг гүйцэтгэсэн:

- “Солонго-1, 2” төслийн гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл олгогдсон техникийн нөхцөл болон зургийн даалгаврын хүрээнд зураг төслийн “ДНТ” ХХК гүйцэтгэж ажлын зураг төсөл зөвшилцсөн;
- “Солонго-1” хорооллын дулаан хангамжийг шинээр 4 ш УДДТ төлөвлөж, 2019 онд хийгдсэн ф400мм хос шугамнаас 2 газраар огтолгоо авч, шинээр 2 ш худаг төлөвлөж тэжээнэ;
- “Солонго-2” хорооллын дулаан хангамжийг шинээр 1 ш УДДТ төлөвлөж, 2019 онд ашиглалтад орсон Ф400мм хос шугамнаас огтолгоо авч, ф250мм хос шугам татаж тэжээнэ.



3. Ус хангамж, ариутгах татуургын талаар:


2019 онд Хан-Уул дүүргийн 10 хороо “Солонго-1” хорооллын Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан. 2020 онд Сонгинохайрхан дүүргийн 1 хороо, Баянголын аманд “Солонго-2” хорооллын барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо Солонго-1, 2 хорооллын гадна дулаан хангамжид холбох ажлын хөрөнгө шийдвэрлэгдсэн. Мөн “Солонго-1”, “Солонго-2” орон сууцны хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний техникийн нөхцөл гаргуулан, ажлын зургийн даалгавар боловсруулан баталсан.

2022 онд Солонго-1, 2 хорооллын 2 төслийн ус хангамжийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцсөн. Ус хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээний ажлын зураг төслийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр “Инж байгууламж” ХХК боловсруулсан ИБ-48/2021 шифтэй ажлын зураг төслийг зөвшилцсөн.



Солонго-1 хорооллын ус хэрэглээ $Q=4079,1$ м³/хон. Техникийн нөхцөл-145/21. Төвийн бохир усны ф600мм ийн шугам сүлжээний угсралтын ажил. Буянт-ухаа-2 хорооллын гадна шугамын ажилтай уялдуулж хийгдэж дууссан.




Солонго-2 хорооллын ус хэрэглээ $Q=1100,1$ м³/хон. Техникийн нөхцөл- 144/21.

4.Мэдээлэл, харилцаа холбооны талаар:

“Солонго-1, 2” төслийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл олгогдсон техникийн нөхцөл болон зургийн даалгаварын хүрээнд 2021 оны 8 сараас хийгдэж эхэлсэн. Зураг төслийн ажлыг “ДНТ” ХХК гүйцэтгэж, хамтран гүйцэтгэгчээр “Ялгуун баян” ХХК ажиллаж ажлын зураг зөвшилцсөн.

Солонго-1: Солонго-1 хорооллын гадна холбоо ЯБ-А3-21-46 шифртэй ажлын ажлын зургийг Ялгуун баян ХХК МХС ТӨХК D207/2021 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зөвшилцсөн.

Солонго-2: Солонго-2 хорооллын гадна холбоо ЯБ-А3-21-47 шифртэй ажлын ажлын зургийг “Ялгуун баян” ХХК МХС ТӨХК D208/2021 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зөвшилцсөн.




5.Цахилгаан хангамжийн талаар:

“Солонго-1, 2” төслийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл олгогдсон техникийн нөхцөл болон зургийн даалгаврын хүрээнд 2021 оны 8 сараас хийгдэж эхэлсэн. Зураг төслийн ажлыг “ДНТ” ХХК гүйцэтгэж, хамтран гүйцэтгэгчээр “Ялгуун баян” ХХК ажиллаж ажлын зураг зөвшилцсөн.

“Солонго-1, 2” хорооллын цахилгаан хангамжийг яармагийн “Ташгай” дэд станцаас холболт хийж 240мм 4 ш 10 кВа-ын кабель шугам татаж тэжээнэ. Төслийн хэмжээнд шинээр 2 ш хувиарлах байгууламж /РП/, 6 ш дамжуулах байгууламж /ХТП/ төлөвлөж цахилгаанаар хангана.

Нийт төслийн хэмжээнд 7 МВ чадал цахилгаан шаардагдах бөгөөд Эрчим хүчний яамнаас “Солонго-1” хороололд 4,800 кВа, “Солонго-2” хороололд 2,250 кВа чадал бүхий техникийн нөхцөл олгосон.



Солонго-1:

- Солонго-1 хорооллын цахилгаан хангамжийн ЯБ-А3-21-46-1 шифртэй ажлын ажлын зургийг “Ялгуун баян” ХХК ЭХЯ-ны 43/2021/252 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зөвшилцсөн.
- Солонго-1 хорооллын түр цахилгаан хангамжийн ТЖ-1.10/2022 шифртэй ажлын зургийг “Түвшинжин” ХХК УБЦТС ТӨХК-ийн 15/01671/22 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж зөвшилцсөн.

Солонго-2:

- Солонго-2 хорооллын цахилгаан хангамжийн ЯБ-А3-21-47-1 шифртэй ажлын зургийг “Ялгуун баян” ХХК ЭХЯ-ны 44/2022/252 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зөвшилцсөн.
- Солонго-2 хорооллын түр цахилгаан хангамжийн ТЖ-110/2022 шифртэй ажлын зургийг “Түвшинжин” ХХК боловсруулж УБЦТС ТӨХК-ийн 15/01672/22 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулж зөвшилцсөн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар